

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Г “Туул сонгино усны нөөц” ХК-ийн оноосон 7
нэрийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК болгон
үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.7, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйл, “Туул сонгино усны нөөц” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар тогтоол, 2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн (РД:5106583) үнэт цаасны бүрдүүлбэрт оноосон нэрийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК болгон өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 13,750,000 ширхэг энгийн хувьцааг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 13,750,000 ширхэг энгийн хувьцаанд нэгийг харьцах нэг гэсэн харьцаагаар хөрвүүлсүгэй.

3. 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн “Монголын хөрөнгийн бирж” ХК дахь үнэт цаасны арилжааг сэргээсүгэй.

4. Үнэт цаасны шинэчилсэн танилцуулгыг олон нийтэд мэдээлэх, цаашид холбогдох хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу авч ажиллахыг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК /Марат Утегенов/-д анхааруулсугай.

5. Тус компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан болон санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгчдийн өмчлөлийн хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг 2010 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК /Марат Утегенов/-д, зохих журмын дагуу үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/,

төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурьдсан хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

7. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгий зохицуулах хорооны 2010 оны 06 сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолын хавсралт

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо (ширхэгээр)
1	Файрбөрд глобал мастер фонд 2 (Firebird global Master fund2)	69,732
2	Евроази капитал Монгол (Euroasia capital Mongolia)	500,003
3	Капитрон банк ХХК	1,000,000
4	Ийст инвестор (Eastinvestor)	1,000,000
5	Оппортунити фонд Opportunity fund	1,600,000
6	Дисковери фонд Discovery fund	2,030,832
7	Файрбөрд глобал мастер фонд 1 (Firebird global Master fund1)	3,424,898
8	Монгол капитал (Mongolia capital)	3,733,752
	НИЙТ	13,359,217

--ooOoo--